



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2020 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот


Нийслэлийн нутаг дэвсгэрт зохион
байгуулагдах бүх нийтийн их цэвэрлэгээний
ажлыг зохион байгуулах тухай

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, гэр болон орон сууцны хорооллын цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах, иргэдийн ая тухтай ажиллаж, амьдрах таатай орчин, нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 2020 онд зохион байгуулагдах бүх нийтийн их цэвэрлэгээний хуваарийг хавсралт ёсоор баталсугай.


2. Дүүргийн нутаг дэвсгэрт их цэвэрлэгээг зохион байгуулах ажлын хэсэг байгуулж, удирдамж, хуваарь, төлөвлөгөөг батлан хэрэгжилтэд хяналт тавих, харьяа газар болон аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг цэвэрлэгээнд бүрэн хамруулж оролцуулах, үр дүнг тайлагнаж ажиллахыг дүүргүүдийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, чиг үүргээр хангаж, бүх нийтийн их цэвэрлэгээний тайлан, дүн мэдээг тухай бүр танилцуулж, ажлаа сурталчилж ажиллахыг Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтэс /С.Аригуун/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн
1021 дугаар тушаалын хавсралт



НИИСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД 2020 ОНД БҮХ НИЙТИЙН ИХ
ЦЭВЭРЛЭГЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУВААРЬ

№	Цэвэрлэгээ зохион байгуулах хугацаа	Байршил	Хариуцан зохион байгуулах мэргэжилтэн	Албан тушаал
1	2020 оны 2-р сарын 08,09	Сар шинийн баярыг угтсан бүх нийтийн их цэвэрлэгээ	Б.Мөнхбаяр	ХХУЗХ-ийн мэргэжилтэн
2	2020 оны 4-р сарын 25	"Их цэвэрлэгээний 90 минут" Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээ.	Хэлтсээрээ	ХХУЗХ
3	2020 оны 5-р сарын 23	Зуслан, ногоон бүсийн их цэвэрлэгээ.	Т.Энх-Амгалан	ХХУЗХ-ийн мэргэжилтэн
4	2020 оны 6-р сарын 13	Шарилжгүй Улаанбаатар аян-5 1-р үе шатыг эхлүүлнэ.	З.Мөнгөнзул	ХХУЗХ-ийн мэргэжилтэн
5	2020 оны 7 дугаар сарын 04,05	Үндэсний их баяр наадам угтсан цэвэрлэгээ	Д.Шийтэр	ХХУЗХ-ийн мэргэжилтэн
4	2020 оны 7-р сарын 18	Шарилжгүй Улаанбаатар аян-5 2-р үе шатыг эхлүүлнэ.	З.Мөнгөнзул	ХХУЗХ-ийн мэргэжилтэн
6	2020 оны 8 дугаар сарын 15	Хичээлийн шинэ жилийг угтсан бүх нийтийн их цэвэрлэгээ	Б.Мөнхбаяр	ХХУЗХ-ийн мэргэжилтэн
7	2020 оны 10-р сарын 10, 11	Нийслэлийн өдрийн угтсан бүх нийтийн их цэвэрлэгээ	Д.Шийтэр	ХХУЗХ-ийн мэргэжилтэн
8	2020 оны 11 дүгээр сарын 21	Халтиргаа гулгаанаас урьдчилан сэргийлэх бүх нийтийн их цэвэрлэгээ	Т.Энх-Амгалан	ХХУЗХ-ийн мэргэжилтэн
9	2020 оны 12-р сарын 12,13	Шинэ жилийн баярыг угтсан бүх нийтийн их цэвэрлэгээ.	З.Мөнгөнзул	ХХУЗХ-ийн мэргэжилтэн